ШУТИС-ийн Ректорын 2012 оны ..4...-р сарын...24...-ны
өдрийн..А73.. тоот тушаалын гуравдугаар хавсралт

# ПРОФЕССОР, БАГШ НАРЫН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ, ИННОВАЦИ БОЛОН СУРГУУЛЬ, ОЛОН НИЙТИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЖЛЫН ҮР ДҮНГ ТООЦОЖ, ҮНЭЛЭХ ЖУРАМ

## НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү журам ШУТИС-ийн мастер төлөвлөгөө болон бүрэлдэхүүн сургуулийн стратеги төлөвлөгөө, инновацийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд профессор, багш нарын идэвхийг нэмэгдүүлэх, залуу багш нарыг сургуулийн нийгмийн үйл хэрэгт өргөн оролцуулах, сургалтын шууд болон шууд бус үйл ажиллагааны хяналт, шинжилгээ, үнэлгээг сайжруулах, кредит үнэлгээний тогтолцоог боловсронгуй болгох зорилготой.

1.2. Энэхүү журмыг ШУТИС-ийн практикт хэрэгжүүлснээр профессор багш нар нь сургалт, эрдэм шинжилгээ, инновацийн ажлын нэгдлийг хангах, шинжлэх ухаан, технологи, инновацийг хөгжүүлэх, нийгмийн өмнө үүрэг хариуцлагыг хүлээж чадах чадвар ба ухамсартай судлаач багш, инженер зохион бүтээгч, нийгмийн ажилтан удирдагч болон өсч хөгжихөд ахиц дэм өгнө.

1.3. Профессор, багш нарын хөдөлмөр нь сургалт явуулах, эрдэм шинжилгээ, инновацийн ажлыг эрхлэх, сургууль, олон нийтийн үйлчилгээ үзүүлэх гэсэн 3 үндсэн үүргийг хэрэгжүүлэхэд чиглэгдэнэ. Үүнтэй уялдуулан кредит цагийн үнэлгээг

А цаг: Сургалт

Б цаг: Эрдэм шинжилгээ, инноваци

В цаг: Сургууль, олон нийтийн үйлчилгээ гэж хуваарилна.

1.4. Энэхүү журмыг Монгол улсын Хөдөлмөрийн тухай хууль (70.1-р заалт: долоо хоногийн ажлын цаг 40 хүртэл байна), ШУТИС-ийн Ректорын 2006 оны 11 сарын 27-ны өдрийн 289 дүгээр тушаалаар батлагдсан Хөдөлмөрийн дотоод журам (5.2-р заалт: профессор, багш нар долоо хоногийн 30-аас доошгүй цагийг үндсэн ажлын байрандаа ажиллана)-аар тогтоогдсон хөдөлмөрийн ноогдол цагт үндэслэн боловсруулав.

1.5. Тус журмыг ШУТИС-ийн профессор, багш нарын Б ба В цагийн гүйцэтгэлийг кредитээр үнэлэхэд ашиглана. Профессор, багшийн нэг кредитийн эквивалентийг 48 цагийн хөдөлмөр гэж үзнэ.

1.6. Профессор, багш нарын судалгаа боловсруулалт, инноваци, сургууль, олон нийтийн үйлчилгээний ажлын гүйцэтгэлийг тухайн бүрэлдэхүүн сургуулийн захирлын зөвлөлийн шийдвэрийн дагуу "Үр дүнгийн менежмент" - ийн сангаас урамшуулна.

1.7. Хичээлийн жилийн улирлын эцэст профессор, багш нар нь өөрийн гүйцэтгэсэн А, Б болон В цагийн гүйцэтгэлийг сургуулийнхаа сурган заах арга зүйн зөвлөл, судалгаа боловсруулалт, инноваци ба технологийн зөвлөл, бүтээмжийн зөвлөл, багийн тэргүүлэх профессор, тэнхимийн эрхлэгч нараар хянуулан дүгнүүлж, дэд захирлууд баталгаажуулна.

1.8. ШУТИС-ийн бүрэлдэхүүн сургуулиуд өөрийн сургууль, мэргэжлийн онцлог, үйл ажиллагааны чиглэлтэй уялдуулан Б ба В цагийн ноогдлын зохист хэмжээг энэхүү журмын хүрээнд өөрчлөн тогтоож болно. Аливаа өөрчлөлт, шинэ үнэлгээний коэффициентийг ШУТИС-ийн захиргаанд албан ёсоор мэдэгдэж байх ёстой.

1.9. Үр дүнгийн менежментийн үнэлгээ болгох кредит үзүүлэлтийг бүрэлдэхүүн сургууль тогтоох эрхтэй. Бусад үзүүлэлтүүд нь ноогдлоос давсан цагаар тооцогдохгүй харин ноогдол хангах үзүүлэлт болж ашиглагдана.

1.10. Профессор, багш нарын А цагийн ноогдлоос Б, В цагийн ноогдол руу шилжүүлж болно.

1.11. Хэрэв маргаантай асуудал гарвал захирлын зөвлөлөөр хэлэлцэж шийдвэрлэнэ.

1.12. Тус журмыг 2011-2012 оны хичээлийн жилийн хаврын улирлаас эхлэн, 1 жилийн хугацаатай мөрдөнө.

ШУТИС-ийн Ректорын 2012 оны 4-р сарын 24-ны өдрийн 173 тоот тушаалын гуравдугаар хавсралт

## ХОЁР. ПРОФЕССОР, БАГШ НАРЫН "ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ, ИННОВАЦИ БОЛОН СУРГУУЛЬ, ОЛОН НИЙТИЙН ҮЙЛЧИЛГЭЭ"-НИЙ АГУУЛГА

### 2.1 Б цаг: Эрдэм шинжилгээ, инновацийн үйл ажиллагаа

2.1.1 **Эрдэм шинжилгээ, инновацийн ажил гүйцэтгэх** (Гадаадын болон дотоод байгууллагын захиалга, гэрээгээр төсөл, хөтөлбөр, захиалгат ажил гүйцэтгэхэд оролцох, төр болон бизнесийн байгууллагад технологи дамжуулах, инноваци нэвтрүүлэх, үйл ажиллагаанд оролцох, нарийн мэргэжлийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх, сургуулийн менежментийг боловсронгуй болгох санал боловсруулах нэвтрүүлэх зэрэг);

2.1.2 **Эрдэм шинжилгээний өгүүлэл, бүтээл бичих, хэвлүүлэх** (Эрдэм шинжилгээний өгүүлэл бичих, дотоодын болон гадаадын шинжлэх ухааны зөвлөмж, аргачлал, стандарт боловсруулах, сэтгүүлд хэвлүүлэх, эрдэм шинжилгээний бусад бүтээл, ном, сурах бичиг гарын авлага бичих, хэвлүүлэх г.м.);

2.1.3 **Эрдэм шинжилгээний илтгэл тавих** (Дотоод, гадаадын Эрдэм шинжилгээний хурал, семинарт илтгэл тавих, хэвлүүлэх, хураангуй хэвлүүлэх );

2.1.4 **Оюуны өмчийн эрх авах, баталгаажуулах** (Патент, ашигтай загвар, зохиогчийн эрхийн гэрчилгээ авах);

2.1.5 **Багийн болон нээлттэй семинарыг зохион байгуулах, оролцох** (Профессорын багийн, сургуулийн, бусад салбар сургууль, эрдэм шинжилгээний байгууллага, компани, өөр байгууллагатай хамтарсан семинарт профессор, багш нар заавал оролцох үүрэг хүлээх)

2.1.6 **Бусад** (Эрдэм шинжилгээний өгүүлэл, бүтээлд шүүмж бичих, ном, сурах бичиг гарын авлага редакторлах, эрдмийн зөвлөл болон эрдмийн зэрэг хамгаалуулах зөвлөлийн гишүүнээр ажиллах, гадаад болон дотоодын эрдэмтэд, судлаачдийн эшлэлд нэр цохогдох, шинжээчдийн баг, ажлын хэсэгт ажиллах, гадаад дотоодын үзэсгэлэн, яармаг, уралдаан, тэмцээнд оролцох, олон улсын болон улсын хэмжээний хурал, семинарт оролцох зэрэг)

### 2.2 В цаг: Сургууль, олон нийтийн үйлчилгээ

Профессор, багш нараас илүү цаг, нэмэлт хүч чармайлт шаардах, ШУТИС-ийн мастер төлөвлөгөөний зорилтын хүрээнд сургуулийн удирдлагаас бодлогоор даалгасан болон нийгэмд тодорхой үр нөлөө үзүүлэх ажлуудыг чанар, үр дүнгээр нь бодитой тооцоолж, үнэлж В цагийн кредитэд хамааруулна.

2.2.1 **Сургуулийн удирдлага, зохион байгуулалттай холбоотой ажлууд** (Баг удирдан зохион байгуулах, лаборатори, кабинет хариуцаж ажиллах, баг, салбар, сургуулийн даалгаварт ажил гүйцэтгэх, багшийн мэргэжлийн шалгалт авах зэрэг);

2.2.2 **Багшийн хөгжил, хамт олны төлөвшилтэй холбоотой ажлууд** (Багшийн хичээлд сууж, зөвлөгөө өгөх, нээлттэй хичээл зохион байгуулах, залуу багш нарт зориулсан сургалт, арга зүй, эрдэм шинжилгээний семинар, лекц хамт олны дунд нийгмийн арга хэмжээг зохион байгуулахад оролцох);

2.2.3 **Оюутан, суралцагсдын хөгжил, төлөвшилтэй холбоотой ажлууд** (Оюутны эрдэм шинжилгээний хурал, семинар, олимпиад, уралдаан, тэмцээнд зөвлөх багшаар ажиллах, оюутнуудын дунд хөгжил төлөвшил, соёл, хүмүүжил, нийгмийн арга хэмжээг зохион байгуулах, оролцох, анги удирдах, оюутнуудад давтлага өгөх, тойм лекц унших);

2.2.4 **Төгсөлт, диплом хамгаалалт, элсэлтийн шалгалттай холбоотой ажлууд** (Бакалавр, магистр, докторын оюутны төгсөлтийн ажлын үзлэг, урьдчилсан хамгаалалтын комисст ажиллах, төгсөлтийн шалгалтын материал боловсруулах зэрэг);

2.2.5 **Сургууль, олон нийтийн үйлчилгээтэй холбоотой ажлууд** (Нийгмийн үйлчилгээний захиалгат сургалт зохион байгуулах, нийгэмд чиглэсэн төрөл бүрийн арга хэмжээнд оролцох, зохион байгуулах, мэргэжлийн сэтгүүл эрхлэн гаргах, клуб, дугуйлан ажиллуулах, вэб сайт ажиллуулах);

2.2.6 **Хамтын ажиллагаа хөгжүүлэхтэй холбоотой ажлууд** (гадаадын болон дотоодын байгууллага, сургууль, эрдэмтэд, менежерүүдтэй хамтран ажиллах төрөл бүрийн арга хэмжээ зохион байгуулах, оролцох, тэдгээрийг өргөжүүлэн хөгжүүлэх замаар сургуулийн сургалт, судалгаа, боловсруулалт, үйлдвэрлэлийн материаллаг баазыг бэхжүүлэх, орлого, хандив оруулах бизнесийн байгууллагуудтай холбоо тогтоох, нийгмийн харилцаа, төлөвшлийг хөгжүүлэх);

2.2.7 Сургуулийн имидж, нэр хүндийг сайжруулах санаа, санаачлага гаргах, хэрэгжүүлэх;

**Жич: Дээрх Б ба В цагийн ажлын агуулгад тухайлан дурьдагдаагүй ажил үйлчилгээг сургуулийн захирлын зөвлөлийн хурлаар хэлэлцэж үр дүн, гүйцэтгэлийн үнэлгээг жич тогтоож байна.**

## ГУРАВ. ПРОФЕССОР, БАГШ НАРЫН Б БА В ЦАГИЙН НООГДОЛ, ҮНЭЛГЭЭ

3.1 Профессор, багш нарын Б ба В цагийн ноогдлын харьцаа нь албан тушаалын ангиллаас хамаарч дараахь ойролцоо хувь хэмжээтэйгээр (*хүснэгт № 1*) тогтоон мөрдүүлнэ.

**Профессор, багш нарын Б ба В цагийн ноогдлын харьцаа** Хүснэгт №1

| д/д | Албан тушаал | Судалгаа, боловсруулалтын ажил (Б цаг) | Сургууль, олон нийтийн үйлчилгээ(В цаг) |
|---|---|---|---|
| 1 | Тэргүүлэх профессор | 70% | 30% |
| 2 | Профессор | | |
| 3 | Дэд профессор | | |
| 4 | Ахлах багш | 60% | 40% |
| 5 | Багш | | |
| 6 | Дадлагажигч багш | 40% | 60% |

3.2 Нэг хичээлийн жилд нэг профессор, багш нарын албан тушаалаас үл хамаарч нийтдээ 20 кредит (А нормт + Б нормт + В нормт) байна. Кредитийн ноогдлын хуваарилалтыг (*хүснэгт № 2*) тодорхойлно.

**Профессор, багш нарын ажлын гүйцэтгэлийн ноогдол** Хүснэгт №2

| д/д | Албан тушаал | Сургалт | Заавал гүйцэтгэх Эрдэм шинжилгээ, инноваци | Сургууль, олон нийтийн үйлчилгээ | Дүн | Кредитийг цагт шилжүүлэх тооцооны үндэслэл | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Нэг хич. жилийн нийт кредит цаг | Нэг долоо хоногт ноогдох ажлын цаг |
| | | А нормт кредит | Б нормт кредит | В нормт кредит | Кредит | (А+Б+В)кр. *48цаг | 960 кр.цаг/ 42 д.х. |
| **Үндсэн багш:** | | | | | | | |
| 1 | Тэргүүлэх профессор | **8** (40%) | **8.4** (42%) | **3.6** (18%) | **20** (100%) | 20*48=960 | 960/42= 22.85 |
| 2 | Профессор | **10** (50%) | **7.0** (35%) | **3.0** (15%) | **20** (100%) | 960 | 22.85 |
| 3 | Дэд профессор | **11** (55%) | **6.3** (31.5%) | **2.7** (13.5%) | **20** (100%) | 960 | 22.85 |
| 4 | Ахлах багш | **13** (65%) | **4.2** (21%) | **2.8** (14%) | **20** (100%) | 960 | 22.85 |
| 5 | Багш | **15** (75%) | **3.0** (15%) | **2.0** (10%) | **20** (100%) | 960 | 22.85 |
| 6 | Дадлагажигч багш | **12-16** (75-80%) | **1.6** (8-10%) | **2.4** (12-15%) | **16-20** (100%) | 960 | 22.85 |

3.3 Профессор, багш нарын Б ба В цагийн ажлын гүйцэтгэлийг ажлын чанар, цар хүрээ, ач холбогдлоос хамааруулан хичээлийн жилийн улирал тутамд албан тушаал бүрээр

эрэмбэлж, сургуулийн захирлын зөвлөлийн шийдвэрийг үндэслэн мөнгөн ба мөнгөн бус (албан тушаалын зэрэглэл ахиулах, тусгайлсан гэрээ байгуулах, хүндэт профессор цол зэрэг олгох г.м) хэлбэрээр урамшуулна. Мөнгөн урамшууллыг "Үр дүнгийн менежмент"-ийн сангаас олгоно.

3.4 Сургуулийн нэр хүндийг олон улсын болон улсын хэмжээнд дуурсагдахуйц онцгой амжилт, бүтээлд сургуулийн захирлын зөвлөлийн шийдвэрийн дагуу тухай бүрд нь "Үр дүнгийн менежмент"-ийн сангаас урамшуулна. Урамшуулалтын хэмжээ, төрлийг сургуулийн захиргааны зөвлөлөөс тогтоож байна.

3.5 Гадаад, дотоод хамтын ажиллагаа, түншлэлийг хөгжүүлсний үндсэн дээр сургуулийн сургалт, эрдэм шинжилгээ, үйлдвэрлэлийн материалаг баазыг бэхжүүлэх, энэ чиглэлийн төрөл бүрийн арга хэмжээг санхүүжүүлэх хүрээнд мөнгөн хандив, тусламж сургуульд оруулахад идэвхитэй нөлөөлж хүч чармайлт гаргасан тохиолдолд тэрхүү хандив, тусламжийн үнийн дүнгийн **5-10% хүртэл** хэмжээний мөнгөн урамшууллыг холбогдох профессор, багш, эсвэл багт олгож болно. Хэрэв тусламж дэмжлэгийг мөнгөн бус хэлбэрээр оруулсан бол нийт өртгийн дүнг тооцоолж **5-10% хүртэл** хэмжээгээр тухайн баг, эсвэл профессор, багшид сургуулиас дэмжлэг авах эрх олгоно (мэргэжил дээшлүүлэх, гадаадын сургалтанд хамрагдах, туршлага судлах, олон улсын хурал, семинарт оролцох зэрэгт давуу эрх олгох).

ХАВСРАЛТ №1

## ДӨРӨВ. ПРОФЕССОР, БАГШ НАРЫН "Б" ЦАГИЙН КРЕДИТИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙГ ТООЦОХ

| д/д | Ажил, үйлчилгээний төрөл | Код | Хэмжих нэгж | Кредит |
|---|---|---|---|---|
| I | **ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ӨГҮҮЛЭЛ, БҮТЭЭЛ БИЧИЖ ХЭВЛҮҮЛЭХ** | | | |
| 1 | **Сэтгүүл болон хурлын эмхтгэл** | | | |
| | - Томсон-Ройтерсийн индекс(IF-JCR)-тэй олон улсын сэтгүүлд өгүүлэл хэвлүүлэх | Б-101 | 1 өгүүлэл | 5.0 |
| | - Томсон-Ройтерсийн индекс(IF-JCR)-гүй боловч мэргэжлийн түвшинд хянагддаг (peer-review) сэтгүүлд өгүүлэл хэвлүүлэх | Б-102 | 1 өгүүлэл | 3.0 |
| | - Мэргэжлийн түвшинд хянагддаггүй гадаадын сэтгүүлд өгүүлэл хэвлүүлэх | Б-103 | 1 өгүүлэл | 2.0 |
| | - Гадаадад зохион байгуулсан олон улсын хурлын эмхэтгэлд бүрэн хэмжээний өгүүлэл хэвлүүлэх | Б-104 | 1 өгүүлэл | 1.0 |
| | - Хүрээлэнгүүдийн эрдэм шинжилгээний бичигт өгүүлэл хэвлүүлэх | Б-105 | 1 өгүүлэл | 1.0 |
| | - Мэргэжлийн сэтгүүлд өгүүлэл хэвлүүлэх | Б-106 | 1 өгүүлэл | 1.0 |
| | - Дотоодод зохион байгуулсан олон улсын хурлын эмхэтгэлд бүрэн хэмжээний өгүүлэл хэвлүүлэх (монгол хэлээр) | Б-107 | 1 өгүүлэл | 1.0 |
| | - Дотоодод зохион байгуулсан эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэлд бүрэн хэмжээний өгүүлэл хэвлүүлэх | Б-108 | 1 өгүүлэл | 0.5 |
| 2 | **Монограф** | | | |
| | - нэг сэдэвт бүтээл | Б-109 | 1 х.х | 0.3 |
| | - гадаад хэлээр бичигдсэн | Б-110 | 1 х.х | 0.4 |
| 3 | **Докторын диссертаци** | | | |
| | - PhD | Б-111 | 1 ажил | 4.0 |
| | - ScD | Б-112 | 1 ажил | 6.0 |
| 4 | **Сурах бичиг** | Б-113 | 1 х.х | 0.3 |
| 5 | **Орчуулгын бүтээл** | Б-114 | 1 х.х | 0.2 |
| 6 | **Гарын авлага** | Б-115 | 1 х.х | 0.2 |
| 7 | **Эрдэм шинжилгээний тайлан** | Б-116 | 1 ажил | 1 хүртэл |
| 8 | **Кейс боловсруулах** | Б-117 | 1 ажил | 0.3 |

ШУТИС-ийн Ректорын 2012 оны ......-р сарын.......-ны өдрийн А/75 тоот тушаалын гуравдугаар хавсралт

UNIVERSITY OF ... MONGOLIAN ... SCIENCE AND TECHNOLOGY

| | | | | |
|---|---|---|---|---|
| 9 | **Бусад** | Б-118<br>Б-119 | | |
| | | Б-120 | | |
| II | **ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРАЛД ИЛТГЭЛ ТАВИХ** | | | |
| 10 | **Олон улсын хурал:**<br>- Уригдсан илтгэл (Keynote, resource person )<br>- Аман илтгэл<br>- Үзүүлэн илтгэл (poster)<br>- Илтгэлийн хураангуй хэвлэгдсэн | Б-201<br>Б-202<br>Б-203<br>Б-204 | 1 илтгэл<br>1 илтгэл<br>1 илтгэл<br>1 илтгэл | 2<br>1.8<br>1.5<br>1.0 |
| 11 | **Үндэсний хэмжээний хурал:**<br>- Уригдсан илтгэл (Keynote, resource person )<br>- Аман илтгэл<br>- Үзүүлэн илтгэл (poster)<br>- Илтгэлийн хураангуй хэвлэгдсэн | Б-205<br>Б-206<br>Б-207<br>Б-208 | 1 илтгэл<br>1 илтгэл<br>1 илтгэл<br>1 илтгэл | 1.0<br>0.8<br>0.5<br>0.3 |
| 12 | **Салбарын хэмжээний хурал:**<br>- Уригдсан илтгэл (Keynote, resource person )<br>- Аман илтгэл<br>- Үзүүлэн илтгэл (poster)<br>- Илтгэлийн хураангуй хэвлэгдсэн | Б-209<br>Б-210<br>Б-211<br>Б-212 | 1 илтгэл<br>1 илтгэл<br>1 илтгэл<br>1 илтгэл | 0.8<br>0.6<br>0.4<br>0.2 |
| 13 | **Сургуулийн хэмжээний хурал**<br>- Үндсэн илтгэл (Keynote)<br>- Аман илтгэл<br>- Үзүүлэн илтгэл (poster)<br>- Илтгэлийн хураангуй хэвлэгдсэн | Б-213<br>Б-214<br>Б-215<br>Б-216 | 1 илтгэл<br>1 илтгэл<br>1 илтгэл<br>1 илтгэл | 0.5<br>0.4<br>0.3<br>0.5 |
| 14 | **Бусад** | Б-217<br>Б-218<br>Б-219 | | |
| III | **ОЮУНЫ ӨМЧИЙН ЭРХ АВАХ, БАТАЛГААЖУУЛАХ** | | | |
| 15 | **Шинэ бүтээл:**<br>- Гадаадад эрхийн хамгаалалт хийгдсэн<br>- Дотоодод эрхийн хамгаалалт хийгдсэн | Б-301<br>Б-302 | 1 бүтээл<br>1 бүтээл | 5.0<br>2.0 |
| 16 | **Ашигтай загвар**<br>- Гадаадад эрхийн хамгаалалт хийгдсэн<br>- Дотоодод эрхийн хамгаалалт хийгдсэн | Б-303<br>Б-304 | 1 бүтээл<br>1 бүтээл | 3.0<br>1.0 |
| 17 | **Зохиогчийн эрхээр баталгаажуулсан бүтээл:**<br>- Ганцаарчилсан бүтээл<br>- Хамтын бүтээл<br>n - Зохиогчийн эрхийн бүтээлд програм хангамжийг тооцно.<br>Хамтын бүтээлийн хувьд ганцаарчилсан бүтээлд ногдох кредитийг зохиогчдын тоо (n)-д хувааж тооцно. | Б-305<br>Б-306 | 1 бүтээл<br>1 бүтээл | 0.5<br>**0.5/n** |
| 18 | **Бусад** | Б-307<br>Б-308<br>Б-309 | | |

ШУТИС-ийн Ректорын 2012 оны ......-р сарын.......-ны
өдрийн А75 тоот тушаалын гуравдугаар хавсралт

| | | | | |
|---|---|---|---|---|
| **IV** | **ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ СУДАЛГААНЫ АЖИЛ БОЛОН ТӨСӨЛ ХӨТӨЛБӨР БОЛОВСРУУЛАХ** | | | |
| 19 | **ШУТИС-ийн санхүүжилттэй төсөл, сэдэвт ажил, инновацийн төсөл** | | | |
| | - Удирдсан | Б-401 | 1 ажил | 0.8 |
| | - Судлаачаар ажилласан | Б-402 | 1 ажил | 0.4-0.6 |
| | - Зөвлөхөөр ажилласан | Б-403 | 1 ажил | 0.6 |
| 20 | **ШУТИС-ийн Технологийн сангийн санхүүжилттэй төсөл, сэдэвт ажил, инновацийн төсөл** | | | |
| | -Удирдсан | Б-404 | 1 ажил | 1.5. |
| | - Судлаачаар ажилласан | Б-405 | 1 ажил | 1.0 |
| | -Зөвлөхөөр ажилласан | Б-406 | 1 ажил | 0.4 |
| 21 | **Төрийн байгууллага, аж ахуйн нэгж, байгууллагын захиалгат төсөл, гэрээт** | | | |
| | - Удирдсан | Б-407 | 1 ажил | 1.0 |
| | - Судлаачаар ажилласан | Б-408 | | 0.4-0.6 |
| | - Зөвлөхөөр ажилласан | Б-409 | | 0.6 |
| 22 | **Гадаадтай хамтарсан болон олон улсын төсөл, хөтөлбөр, гэрээт ажил** | | | |
| | - Удирдсан | Б-410 | | 2.5 |
| | - Судлаачаар ажилласан | Б-411 | 1 ажил | 1.5 |
| | - Зөвлөхөөр ажилласан | Б-412 | | 1.5 |
| 23 | **Технологи дамжуулах, инноваци нэвтрүүлэх ажил** | | | |
| | - Бусад байгууллагад нэвтрүүлсэн инноваци, санаа, үр дүн (технологи) | Б-413 | 1 үр дүн | 1.0-1.5 |
| | - Хэрэгжүүлсэн аргачлал, зөвлөмж, стандарт, инженерингийн туслалцаа | Б-414 | 1 үр дүн | 1.0-1.5 |
| 24 | **Бусад** | Б-415 | | |
| | | Б-416 | | |
| | | Б-417 | | |
| **V** | **СУДАЛГАА, БОЛОВСРУУЛАЛТЫН БУСАД АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ** | | | |
| 25 | **Эрдэм шинжилгээний сэтгүүл эрхлэн гаргах** | Б-501 | 1 сэтгүүл | 1 |
| 26 | **Эрдэм шинжилгээний сэтгүүлийн редакцийн зөвлөлийн гишүүнээр ажиллах** | | | |
| | - Дотоодын сэтгүүл | Б-502 | 1 хич.жил | 0.5 |
| | - Гадаадын сэтгүүл | Б-503 | 1 хич.жил | 1 |
| 27 | **Эрдэм шинжилгээний бүтээл редакторлах, шүүмж бичих** | | | |
| | - Мэргэжлийн сурах бичиг, гарын авлага | Б-504 | 1 х.х | 0.1 |
| | - Нэг сэдэвт бүтээл, ном | Б-505 | 1 х.х | 0.1 |
| | - Орчуулгын бүтээл | Б-506 | 1 х.х | 0.2 |
| | - Эрдэм шинжилгээний өгүүллийн лиценз | Б-507 | 1 х.х | 0.1 |
| 28 | **Гадаадын мэргэжлийн сэтгүүлд хэвлэгдэх өгүүлэлд шүүмж бичих** | Б-508 | 1 өгүүлэл | 0.3 |
| 29 | **Стандарт боловсруулах** | | | |
| | - Улсын стандарт боловсруулахад оролцох | Б-509 | 1 стандарт | 1.0 |
| | - Салбарт, байгууллагын стандарт боловсруулахад оролцох | Б-510 | 1 стандарт | 0.8 |
| | - Зөвлөмж, санал, тооцоо боловсруулах | Б-511 | 1 стандарт | 0.6 |
| 30 | **Докторын ажил удирдах, шүүмж бичих** | | | |
| | - Доктор(ScD)-ын диссертацийн ажилд шүүмж бичих | Б-512 | 1 ажил | 0.5 |
| | - Доктор(PhD)-ын диссертацийн ажилд шүүмж бичих | Б-513 | 1 ажил | 0.3 |
| | - Хамгаалсан докторын ажлыг удирдах | Б-514 | 1докторант | 3.0 |

ШУТИС-ийн Ректорын 2012 оны ......-р сарын.......-ны өдрийн А73 тоот тушаалын гуравдугаар хавсралт

| | | | | |
|---|---|---|---|---|
| **IV** | **ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ СУДАЛГААНЫ АЖИЛ БОЛОН ТӨСӨЛ ХӨТӨЛБӨР БОЛОВСРУУЛАХ** | | | |
| 19 | **ШУТИС-ийн санхүүжилттэй төсөл, сэдэвт ажил, инновацийн төсөл** | | | |
| | - Удирдсан | Б-401 | 1 ажил | 0.8 |
| | - Судлаачаар ажилласан | Б-402 | 1 ажил | 0.4-0.6 |
| | - Зөвлөхөөр ажилласан | Б-403 | 1 ажил | 0.6 |
| 20 | **ШУТИС-ийн Технологийн сангийн санхүүжилттэй төсөл, сэдэвт ажил, инновацийн төсөл** | | | |
| | -Удирдсан | Б-404 | 1 ажил | 1.5. |
| | - Судлаачаар ажилласан | Б-405 | 1 ажил | 1.0 |
| | -Зөвлөхөөр ажилласан | Б-406 | 1 ажил | 0.4 |
| 21 | **Төрийн байгууллага, аж ахуйн нэгж, байгууллагын захиалгат төсөл, гэрээт** | | | |
| | - Удирдсан | Б-407 | 1 ажил | 1.0 |
| | - Судлаачаар ажилласан | Б-408 | | 0.4-0.6 |
| | - Зөвлөхөөр ажилласан | Б-409 | | 0.6 |
| 22 | **Гадаадтай хамтарсан болон олон улсын төсөл, хөтөлбөр, гэрээт ажил** | | | |
| | - Удирдсан | Б-410 | | 2.5 |
| | - Судлаачаар ажилласан | Б-411 | 1 ажил | 1.5 |
| | - Зөвлөхөөр ажилласан | Б-412 | | 1.5 |
| 23 | **Технологи дамжуулах, инноваци нэвтрүүлэх ажил** | | | |
| | - Бусад байгууллагад нэвтрүүлсэн инноваци, санаа, үр дүн (технологи) | Б-413 | 1 үр дүн | 1.0-1.5 |
| | - Хэрэгжүүлсэн аргачлал, зөвлөмж, стандарт, инженерингийн туслалцаа | Б-414 | 1 үр дүн | 1.0-1.5 |
| 24 | **Бусад** | Б-415 | | |
| | | Б-416 | | |
| | | Б-417 | | |
| **V** | **СУДАЛГАА, БОЛОВСРУУЛАЛТЫН БУСАД АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ** | | | |
| 25 | **Эрдэм шинжилгээний сэтгүүл эрхлэн гаргах** | Б-501 | 1 сэтгүүл | 1 |
| 26 | **Эрдэм шинжилгээний сэтгүүлийн редакцийн зөвлөлийн гишүүнээр ажиллах** | | | |
| | - Дотоодын сэтгүүл | Б-502 | 1 хич.жил | 0.5 |
| | - Гадаадын сэтгүүл | Б-503 | 1 хич.жил | 1 |
| 27 | **Эрдэм шинжилгээний бүтээл редакторлах, шүүмж бичих** | | | |
| | - Мэргэжлийн сурах бичиг, гарын авлага | Б-504 | 1 х.х | 0.1 |
| | - Нэг сэдэвт бүтээл, ном | Б-505 | 1 х.х | 0.1 |
| | - Орчуулгын бүтээл | Б-506 | 1 х.х | 0.2 |
| | - Эрдэм шинжилгээний өгүүллийн лиценз | Б-507 | 1 х.х | 0.1 |
| 28 | **Гадаадын мэргэжлийн сэтгүүлд хэвлэгдэх өгүүлэлд шүүмж бичих** | Б-508 | 1 өгүүлэл | 0.3 |
| 29 | **Стандарт боловсруулах** | | | |
| | - Улсын стандарт боловсруулахад оролцох | Б-509 | 1 стандарт | 1.0 |
| | - Салбарт, байгууллагын стандарт боловсруулахад оролцох | Б-510 | 1 стандарт | 0.8 |
| | - Зөвлөмж, санал, тооцоо боловсруулах | Б-511 | 1 стандарт | 0.6 |
| 30 | **Докторын ажил удирдах, шүүмж бичих** | | | |
| | - Доктор(ScD)-ын диссертацийн ажилд шүүмж бичих | Б-512 | 1 ажил | 0.5 |
| | - Доктор(PhD)-ын диссертацийн ажилд шүүмж бичих | Б-513 | 1 ажил | 0.3 |
| | - Хамгаалсан докторын ажлыг удирдах | Б-514 | 1докторант | 3.0 |

ШУТИС-ийн Ректорын 2012 оны ......-р сарын.......-ны өдрийн. А/73 тоот тушаалын гуравдугаар хавсралт

| | | | | |
|---|---|---|---|---|
| | - Хамгаалсан докторын ажлын зөвлөх | Б-515 | 1 докторант | 1.0 |
| 31 | **Бусдын бүтээлд эшлэлээр нэр цохогдох** | | | |
| | -Гадаадын рецеанит сэтгүүлүүдэд, гадаадын зохиогчдын бүтээлд | Б-516 | 1 удаа | 1.0 |
| | - Гадаадын зохиогчдын бүтээлд (гадаадын хэвлэлээр) | Б-517 | 1 удаа | 0.8 |
| | - Дотоодын хэвлэлд (дотоод ба гадаадын зохиогчдын бүтээлд) | Б-518 | 1 удаа | 0.5 |
| 32 | **Оюутан удирдаж эрдэм шинжилгээний хуралд илтгэл хэлэлцүүлэх (давхардуулж тооцохгүй):** | | | |
| | - Улс/ШУТИС, бусад сургуульд 1-3 байр | Б-519 | 1 илтгэл | 0.5 |
| | - Бүрэлдэхүүн сургуульд 1-3 байр | Б-520 | 1 илтгэл | 0.3 |
| | - Илтгэл тавиулж, оролцуулсан | Б-521 | 1 илтгэл | 0.1 |
| 33 | **Бусад** | Б-522 | | |
| | | Б-523 | | |
| | | Б-524 | | |

## ТАВ. ПРОФЕССОР, БАГШ НАРЫН “В” ЦАГИЙН КРЕДИТИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙГ ТООЦОХ

| д/д | Бүтээлч ажил | Код | Хэмжих нэгж | Кредит |
|---|---|---|---|---|
| I | **ПРОФЕССОРЫН БАГИЙН СЕМИНАР ЗОХИОН БАЙГУУЛАХ** | | | |
| 1 | **Багийн семинарт оролцох** | | | |
| | - Проф/Багшийн оролцоотой | В-101 | Оролцсны идэвхи | 0.1 |
| | - Бакалавр оюутны оролцоотой | В-102 | Оролцсны идэвхи | 0.2 |
| | - Магистрантын оролцоотой | В-103 | Оролцсны идэвхи | 0.3 |
| | - Докторантын оролцоотой | В-104 | Оролцсны идэвхи | 0.3 |
| 2 | **Нээлттэй семинарт оролцох** | | | |
| | - Проф/Багшийн оролцоотой | В-105 | Оролцсны идэвхи | 0.2 |
| | - Бакалавр оюутны оролцоотой | В-106 | Оролцсны идэвхи | 0.2 |
| | - Магистрантын оролцоотой | В-107 | Оролцсны идэвхи | 0.3 |
| | - Докторантын оролцоотой | В-108 | Оролцсны идэвхи | 0.3 |
| 3 | **Семинарт бэлтгэх, зохион байгуулах** | | | |
| | - Проф/Багшийн оролцоотой | В-109 | 1 удаа | 0.4 |
| | - Бакалаврын оролцоотой | В-110 | 1 удаа | 0.4 |
| | - Магистрантын оролцоотой | В-111 | 1 удаа | 0.4 |
| | - Докторантын оролцоотой | В-112 | 1 удаа | 0.4 |
| 4 | **ШУТИС-ийн хэмжээний сургалт, семинар, бага хуралд оролцох** | | | |
| | - ШУТИС-ийн хэмжээнд | В-113 | 1 удаа | 0.3 |
| | - Улсын болон бусад байгууллагатай | В-114 | 1 удаа | 0.4 |
| | - Салбарын болон бизнесийн байгууллагатай | В-115 | 1 удаа | 0.4 |
| 5 | **Бусад** | В-116 | | |
| | | В-117 | | |
| | | В-118 | | |
| II. | **СУРГУУЛИЙН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТТАЙ ХОЛБООТОЙ АЖЛУУД** | | | |
| 6 | ШУТИС-ийн болон сургуулийн эрдмийн зөвлөлийн гишүүн (давхардуулж тооцож болно) | В-201 | 1 хич. Жил | 1.0 |
| 7 | Сургуулийн захиргааны шийдвэрээр Сургалт, заах арга, сургалтын технологийг боловсронгуй болгох, | В-202 | 1 удаа | 1.0 |
| | Заавар, дүрэм, бусад баримт бичиг боловсруулах | В-203 | 1 удаа | 0.9 |

ШУТИС-ийн Ректорын 2012 оны ......-р сарын.......-ны өдрийн А/73 тоот тушаалын гуравдугаар хавсралт

| | | | | |
|---|---|---|---|---|
| | Бусад үүрэгт ажил | В-204 | 1 удаа | 0.8 |
| 8 | Сургалт, заах арга зүйн зөвлөл, Эрдэм шинжилгээ инновацийн зөвлөл, Бүтээмж, үр дүнгийн зөвлөлийн гишүүн | В-205 | Хагас жил тутамд | 1.0 |
| 9 | Докторын зэрэг хамгаалуулах зөвлөлийн гишүүнээр ажиллах | В-206 | 1 удаа | 0.2 |
| 10 | **Бусад** | В-207<br>В-208<br>В-209 | | |
| III | **БАГШИЙН ХӨГЖИЛ, ХАМТ ОЛНЫ ТӨЛӨВШИЛТЭЙ ХОЛБООТОЙ АЖЛУУД** | | | |
| 11 | Багшийн хичээлд сууж зөвлөгөө өгөх эсвэл хичээлд нь сууж зөвлөгөө авах | В-301 | 1 удаа | 0.1 |
| 12 | Багшийг дагалдан ажиллах эсвэл дагалдуулах | В-302 | Хагас жил тутамд | 0.5 |
| 13 | Нээлттэй хичээл зохион байгуулах | В-303 | 1 удаа | 0.2 |
| 14 | Залуу багш нарт зориулан сургалт, арга зүй, эрдэм шинжилгээний семинар, лекц зохион байгуулах | В-304 | 1 удаа | 0.5 |
| 15 | **Эрдэм шинжилгээний хурал, семинар зохион байгуулах**<br>- Олон улсын хурал, семинар<br>- Улсын хэмжээний хурал, семинар<br>- Салбарын хэмжээний хурал, семинар<br>- Сургуулийн хэмжээний хурал, семинар | <br>В-305<br>В-306<br>В-307<br>В-308 | <br>1 арга хэмжээ<br>1 арга хэмжээ<br>1 арга хэмжээ<br>1 арга хэмжээ | <br>1.0<br>0.8<br>0.6<br>0.4 |
| 16 | **Урлагийн үзлэг наадам, спортын тэмцээн, уралдаан**<br>- зохион байгуулах<br>- оролцох | <br>В-309<br>В-310 | <br>1 арга хэмжээ<br>1 арга хэмжээ | <br>0.4<br>0.2 |
| 17 | -Хамт олны тэмдэглэлт арга хэмжээ | В-311 | 1 арга хэмжээ | 0.1 |
| | **Бусад** | В-312<br>В-313<br>В-314 | | |
| IV | **ОЮУТАН, СУРАЛЦАГЧДЫН СУРАЛЦАХ, ХӨГЖИХ, ТӨЛӨВШИЛТЭЙ ХОЛБООТОЙ АЖЛУУД** | | | |
| 18 | Оюутны эрдэм шинжилгээний хурал, олимпиад, уралдаан тэмцээн зохион байгуулах, оюутан бэлтгэн оролцуулах комисст болон шүүгчээр ажиллах<br>- Олон улсын хэмжээнд<br>- Улсын хэмжээнд<br>- Сургуулийн хэмжээнд<br>- Баг, тэнхимийн хэмжээнд | <br>В-401<br>В-402<br>В-403<br>В-404 | <br>1 арга хэмжээ<br>1 арга хэмжээ<br>1 арга хэмжээ<br>1 арга хэмжээ | <br>2.0<br>1.0<br>0.6<br>0.4 |
| 19 | **Оюутны эрдэм шинжилгээний дугуйлан, клуб:**<br>- Удирдах,<br>- Зохион байгуулах, / n- оролцогчдын тоо /<br>- Үйл ажиллагаанд оролцох | <br>В-405<br>В-406<br>В-407 | <br>1 улирал<br>1 улирал<br>1 улирал | <br>0.5<br>0.5/n<br>0.5 |
| 20 | **Зөвлөх багшаар ажиллах** | В-408 | 1 улирал | 1.0 |
| 21 | **Суралцагчдын хүмүүжил, төлөвшлийн ажил:**<br>Соёл, олон нийтийн ажил зохион байгуулах | В-409 | 1 арга хэмжээ | 0.5 |
| 22 | БСШУЯ, Гадны байгууллагууд, ШУТИС, Сургуулийн шаардлагаар оюутнуудын талаарх судалгаа хийх | В-410 | 1 удаа | 0.2 |
| 23 | Багш, оюутнуудад зориулсан блог, вэб хуудас хөгжүүлэн ажиллуулсан байдал | В-411 | 1 ажил | 0.2 |
| 24 | Зөвлөх ангийн оюутнуудтай цагийн хуваарийн дагуу ажилласан байдал | В-412 | Хагас жил тутамд | 0.2 |
| 25 | Оюутны мэдлэгийг гадаадын их дээд сургуулиудын түвшинд хүргэх, сурах бичиг, гарын авлагаар бүрэн хангасан байдал | В-413 | Хагас жил тутамд | 1.0 |
| 26 | Оюутнуудад давтлага өгөх, тойм лекц унших | В-414 | 1 удаа | 0.1 |
| 27 | **Бусад** | В-415<br>В-416<br>В-417 | | |

ШУТИС-ийн Ректорын 2012 оны ......-р сарын.......-ны өдрийн А/73 тоот тушаалын гуравдугаар хавсралт

| | | | | |
|---|---|---|---|---|
| V | **ТӨГСӨЛТ, ХАМГААЛАЛТ, ШАЛГАЛТТАЙ ХОЛБООТОЙ АЖЛУУД** | | | |
| 28 | **Бакалаврын сургалтын хөндлөнгийн болон батлах шалгалт бичгээр авсан комиссын гишүүн**<br>- 30 хүнтэй бүлэгт<br>- 30-оос дээш хүн бүрт | B-501<br>B-502 | Бүлгээр<br>Бүлгээр | 3/.24<br>0.1/24 |
| 29 | **Магистрын элсэлтийн шалгалт амаар авсан комиссын гишүүн**<br>- 1-5 хүнтэй бүлэгт<br>- 5-аас дээш хүн бүрт | B-503<br>B-504 | Бүлгээр<br>Бүлгээр | 2/.24<br>0.4/24 |
| 30 | **Докторын элсэлтийн шалгалт амаар авсан комиссын гишүүн**<br>- 1-4 хүнтэй бүлэгт<br>- 4-аас дээш хүн бүрт | B-505<br>B-506 | Бүлгээр<br>Бүлгээр | 2/.24<br>0.4/24 |
| 31 | **Багшийн мэргэжлийн шалгалт авсан комиссын гишүүн**<br>- 1-4 хүнтэй бүлэгт<br>- 4-аас дээш хүн бүрт | B-507<br>B-508 | Бүлгээр<br>Бүлгээр | 2/.24<br>0.4/24 |
| 32 | **Магистр, докторын гадаад хэлний нэгдсэн шалгалт бичгээр авсан комиссын гишүүн**<br>- 30 хүнтэй бүлэгт<br>- 30-60 хүнтэй бүлэгт<br>- 60-аас дээш | B-509<br>B-510<br>B-511 | Бүлгээр<br>Бүлгээр<br>Бүлгээр | 4/24<br>4/24<br>4/24 |
| 33 | Бакалавр, магистр, докторын оюутны төгсөлтийн ажлын үзлэг, урьдчилсан хамгаалалтын комисст ажиллах, төгсөлтийн шалгалтын материал боловсруулах n- оролцогчдын тоо | B-512 | Бүлгээр | 0.2/n |
| 34 | **Бусад** | B-513<br>B-514<br>B-515 | | |
| VI | **СУРГУУЛИЙН НИЙГЭМД ҮЗҮҮЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭТЭЙ ХОЛБООТОЙ АЖЛУУД** | | | |
| 35 | Нийтэд мэдлэг түгээх, нийгмийг соён гэгээрүүлэх зорилго бүхий эрдэм шинжилгээний хялбаршуулсан ба сурталчилгааны өгүүлэл хэвлүүлэх | B-601 | 1 өгүүлэл | 0.3 |
| 36 | Нийтэд мэдлэг түгээх, нийгмийг соён гэгээрүүлэх чиглэлээр лекц унших | B-602 | 1 лекц | 0.2 |
| 37 | **Нийгэм, олон нийтэд чиглэсэн үйл ажиллагаа**<br>- Телевиз, радиогийн нэвтрүүлэгт оролцож, мэргэжлээ сурталчлах, мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх<br>- Өдөр тутмын сонин хэвлэлд өгүүлэл, нийтлэл бичих<br>- Үндэсний зөвлөхөөр ажиллах<br>- Ажлын хэсгийн гишүүнээр ажиллах | B-603<br>B-604<br>B-605<br>B-606 | 1 нэвтрүүлэг<br>1 нийтлэл<br>1 удаа<br>1 удаа | 0.5<br>0.5<br>0.5<br>0.5 |
| 38 | **Бусад** | B-607<br>B-608<br>B-609 | | |
| VII | **ГАДААД БОЛОН ДОТООД ХАМТЫН АЖИЛЛАГАА ХӨГЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБООТОЙ АЖЛУУД** | | | |
| 40 | **Гадаад, дотоод арга хэмжээ:**<br>- зохион байгуулах<br>- оролцох | B-701<br>B-702 | 1 арга хэмжээ<br>1 арга хэмжээ | 0.2<br>0.1 |
| 41 | **Сургуулийн сургалт- судалгаа- үйлдвэрлэлийн материалаг баазыг бэхжүүлэх, орлого, хандив оруулах:**<br>- Хөрөнгө оруулалтаар материалаг бааз бэхжүүлэх | B-703 | 1 ажил<br>1 ажил | Тушаалаар<br>Тушаалаар |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | - Орлого, хандив оруулах | В-704 | 1 ажил | Тушаалаар |
| | - Тэтгэлэг авч, сургуульд орлого оруулах | В-705 | 1 ажил | Тушаалаар |
| 42 | **Бусад** | В-706<br>В-707<br>В-708 | | |

MONGOLIAN UNIVERSITY OF SCIENCE AND TECHNOLOGY